


НӨЛӨӨЛЛИЙН МЭДҮҮЛГИЙН ТАЛААРХ ОЙЛГОЛТ

Нөлөөллийн
мэдүүлэг
гэж юу вэ?



Шүүгч, шүүх бүрэлдэхүүнд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад аливаа этгээдээс нөлөөлөхөөр оролдсон эсэх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан баримт бичгийг хэлнэ.



© CasStockPhoto.com - cas71115627

Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх зорилго:

- Тухайн хэрэг, маргааныг өөрт ашигтай байдлаар шийдвэрлүүлэхийн тулд шүүгчид хөндлөнгөөс танил талаараа яриулах, утсаар ярих, бэлэг өгөх, бэлэн мөнгө амлах, хоолонд оруулах гэх зэргээр нөлөөлж болохгүй,
- Нөлөөллийн мэдүүлэг хөтлөхийн ач холбогдол нь хариуцлага хүлээлгэнэ гэхээсээ илүү урьдчилан сэргийлэх арга хэмжээ юм.

Шүүгчид аливаа байдлаар нөлөөлсөн бол дараах хариуцлагыг хүлээнэ.

Шүүгчийн хараат бус байдалд халдсан, шүүхийн үйл ажиллагаанд саад учруулсан, нөлөөлсөн хэн боловч хуулийн хариуцлага хүлээнэ.



Шүүгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад аливаа хэлбэрээр нөлөөлсөн тохиолдолд Эрүүгийн хуульд зааснаар 5.400.0- 27.0 сая төгрөгөөр торгох, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1 жилээс 5 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэнэ. Мөн

Зөрчлийн тухай хуульд зааснаар хүнийг 1.0 /Нэг сая/ төгрөгөөр, хуулийн этгээдийг 10.0 /Арван сая/ төгрөгөөр торгоно.



Иргэн таны хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдөж хэрэг маргаанаа шийдвэрлүүлэхээр Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн анхан шатны шүүх, давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хандсан тохиолдолд шүүгчийн туслах танд нөлөөллийн мэдүүлгийг тайлбарлаж, баримтад гарын үсэг зуруулж, баталгаажуулсан байна.

Мэдээлэл бэлтгэсэн:
Шүүгчийн туслах Ө.Бямбасайхан